



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2020 оны 6 дугаар сар


Улаанбаатар
2020



1 Мөнгөний нийлүүлэлт


Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өсч 21.3 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 7.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.6 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 0.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -2.8 нэгж хувийг төгрөгийн харилцах тус тус бүрдүүлж байна.

Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 5.5%-иар нэмэгдсэн байна.



Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 3.4 хувиар өсөхөд иргэдийн төгрөг болон гадаад валютын хадгаламж, хувийн байгууллагын төгрөгийн харилцах, гадаад валютын хадгаламж нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин улсын байгууллагын болон санхүүгийн байгууллагын төгрөгийн харилцах буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 3.4 хувиар өсөв.



Нийт хадгаламжийн хэмжээ 15.4 их наяд төгрөг байгаагаас 86.4 хувь буюу 13.3 их наяд төгрөг нь иргэдийн, 13.6 хувь буюу 2.1 их наяд


төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 28.3 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 26.5 хувийг, байгууллагын хадгаламжийн 39.9 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 11.1%-иар өсчээ.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.5 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.9 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулсан M2 мөнгөний өсөлтийн 3.9 нэгж хувийг ГЦА, 1.6 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна.

Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.




ГЦА-ын өсөлтөд Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн бол ДЦА-ын өсөлт нь Монголбанк болон банкууд дотоодын бонд худалдан авсантай холбоотой байна.

2 Банкуудын зээл

2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурч 17.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс хувийн байгууллагын зээл 3.0 хувиар буурч 8.2 их наяд төгрөгт, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 7.6 хувиар буурч 8.7 их наяд төгрөгт хүрчээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурч 17.2 их наяд төгрөг болов.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 их наяд төгрөг буюу 9.5 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 199.8 тэрбум төгрөгөөр өсч, эргэн төлөгдсөн зээл 42.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-2: Тайлант сард 1,782.0 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,793.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 3.9 хувь буюу 76.8 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 76.3 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 77.5 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна.

Зураг 2-3: Нийт зээлийн 11.1% нь чанаргүй зээл, 5.8% нь хугацаа хэтэрсэн зээл байна.




Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,911.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 53.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээлийн 12.4 хувь нь гадаад валютын зээл байна.

Чанаргүй зээлийн 21.9 хувийг уул уурхай, 19.6 хувийг боловсруулах, 12.2 хувийг барилга, 8.2 хувийг үл хөдлөх, 6.9 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 76.3% хувийн байгууллагын, 22.8% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард 65.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын зээлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, барилгын салбарын зээл 77.3 тэрбум, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын зээл 46.5 тэрбум, худалдааны салбарын зээл 31.6 тэрбум, тээвэр, агуулахын салбарын зээл 12.7 тэрбум, боловсруулах салбарын зээл 5.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол уул уурхайн салбарын зээл 66.0 тэрбум, боловсролын салбарын зээл 41.8 тэрбум төгрөгөөр буурчээ.

Тайлант сард хувийн байгууллагад 946.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 7.3 хувь буюу 69.3 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Тайлант сард худалдаа, уул уурхай, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 40.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 41% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 27%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.




Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн зээлийг задалж авч үзвэл, өмнөх сараас ипотекийн зээл 67 тэрбум (МИК-д шилжсэн багцыг хассанаар), хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа болон үйлчилгээний салбарын зээл 30.6 тэрбум, худалдааны зээл 20.5 тэрбум төгрөгөөр тус тус өсч, цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 43.2 тэрбум төгрөгөөр, малчны зээл 9.1 тэрбум, картын зээлийн үлдэгдэл 7.5 тэрбум төгрөгөөр, хадгаламж барьцаалсан зээлийн үлдэгдэл 7.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант сард иргэдэд 963.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.8 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Иргэдийн зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр, картын зээл эзэлж байна.




*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

3 Ипотекийн зээл

2020 оны 6 дугаар сарын байдлаар 98,355 зээлдэгч нийт 4,730.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 72,982 зээлдэгч 3,489.4 тэрбум төгрөгийн зээл авчээ.


Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 5.4%-д хүрэв.



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 73.8 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.9 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Зураг 3-2: Нийт зээлийн 16.9% буюу 800.5 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

Нийт ипотекийн зээлийн 16.9 хувь буюу 800.5 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл³-ийн 76.3 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.3 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.4 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.3 хувь нь хэвийн, 1.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.9 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 51.1 хувийг хөтөлбөрийн зээл, 47.9 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.0 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 18.3 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 25.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Тайлант сард 1,402 зээлдэгчид 92.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 61.9% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

Зураг 3-4: Тайлант сард шинээр 1,402 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.




Эх сурвалж: Монголбанк

³ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар, өмнөх сараас 1.2 нэгж хувиар буурч 10.5 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.5 хувьтай байна.




Эх сурвалж: Монголбанк

4 Хүү

4.1 Шинээр татсан хадгаламжийн хүү


2020 оны 6 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.0 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.3 хувь байна. Гадаад валютын ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурчээ.

Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 0.6 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 11.4%, хугацаагүй хадгаламжийн хүү 5.5% байна.




Эх сурвалж: Монголбанк

4.2 Шинээр олгосон зээлийн хүү


Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.3⁶ хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.3 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 4-3: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 16.3% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.7 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк


Иргэдэд 963.6 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 69.3 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

⁶ Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

4.3 Үлдэгдлээр хадгаламжийн хүү

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 11.0 хувьтай байна. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурав.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү 11.0% байна.




Эх сурвалж: Монголбанк

Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.1 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.5 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 9.8 хувьтай байна.

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2020 оны 6 дугаар сарын байдлаар 6.3 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.7 нэгж хувиар буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

4.5 Зээлийн үлдэгдлээр хүү

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 17.0 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.4 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.1⁷ хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 11.7 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.7 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.4 хувьтай байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 2-5 жилийн хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар тэрбум ₮



Эх сурвалж: Монголбанк

⁷ Хөтөлбөрийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.


5 Инфляци

5.1 Улсын инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 6 дугаар сарын байдлаар жилийн 2.8 хувь, сарын инфляци 0.3 хувь байна.

Жилийн инфляцийг авч үзвэл хүнсний барааны үнийн өсөлт нь хүнсний ногооны үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс бараа болон боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна. Харин тээврийн бүлгийн үнэ буурсан байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляци 2.8 хувьтай байна.




Эх сурвалж: УСХ

5.2 Улаанбаатар хотын жилийн инфляци

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 6 дугаар сарын байдлаар 2.4 хувь байгаа ба 1.3 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 1.1 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 5-2: УБ хотын жилийн инфляци 2.4 хувьд хүрэв.



Эх сурвалж: УСХ


Хүнсний барааны бүлгийн үнэд мах, махан бүтээгдэхүүн болон талх, нарийн боовны

үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэд хувцас, бөс бараа гутал, орон сууц, ус цахилгаан түлшний бүлгийн үнийн өсөлт нөлөөлжээ. Харин тээврийн бүлгийн үнэ буурсан байна.

5.3 Улаанбаатар хотын сарын инфляци

Өмнөх сартай харьцуулахад УБ хотын хэмжээнд инфляци 0.4 хувьтай байна. Үүний 0.36 нэгж хувийг хүнсний бараа, 0.08 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Хүнсний барааны үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний болон хүнсний ногооны үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд зочид буудал, нийтийн хоол бүлэг болон бусад үйлчилгээний бүлгийн өссөн нөлөөлжээ

Зураг 5-3: УБ хотын сарын инфляци -0.1 хувь.



Эх сурвалж: УСХ


6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,823.89 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,816.26 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.

жилийн өсөлт %




Эх сурвалж: Монголбанк

6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 1.8 нэгж хувиар суларч 399.52 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 394.6 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 399.5 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.

жилийн өсөлт %




Эх сурвалж: Монголбанк


ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. M2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /сектороор/




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа /зээлийн төрлөөр/




Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа /салбараар/




Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн /тэрбум ₮/




Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Зураг 2.14. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Тухайн сард олгосон ипотекийн зээл, санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар




Зураг 3.4. Тухайн сард орон нутагт олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгө, ашиглалтанд орсон оноор




Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл



4. ХҮҮ

Зураг 4.1. Хугацаагүй хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.2. Хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт

